



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 08 сарын 07 өдөр

Дугаар А/882

Улаанбаатар хот

Тээврийн хэрэгсэл балансаас  
балансад шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 78 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1 дэх заалт, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 5 дугаар зүйлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Байгууллагын балансад бүргэлтэй, хавсралтад заасан тээврийн хэрэгслүүдийг балансаас балансад шилжүүлж, данс бүртгэлээсээ хасахыг “Нийслэлийн Төр захиргааны авто бааз” УТҮГ (Э.Болор-эрдэнэ), Нийслэлийн Өмчийн харилцааны газар (Ч.Сайханбаяр), “Улаанбаатар зам засвар, арчлалтын газар” ОНӨААТҮГ (Б.Галхүү), Чингэлтэй дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ажлын алба (М.Туяа), Чингэлтэй дүүргийн “Нийтлэг үйлчилгээний газар” ОНӨТҮГ (С.Энхтайван)-т тус тус зөвшөөрсүгэй.

2. Тээврийн хэрэгслийг зохих журмын дагуу бүртгэн авч, өмчийн ашиглалт, хамгаалалтыг хариуцан ажиллахыг “Улаанбаатар хотын музей” (П.Даваасүрэн), “Улаанбаатар хотын тогтвортой авто зам, тээвэр төсөл хэрэгжүүлэх нэгж” (Х.Булгаа), Нийслэлийн Онцгой байдлын газар (А.Дашням), Нийгмийн хамгааллын тусгай төв (Ш.Мөнхцэцэг), “Зорчигч тээврийн нэгтгэл” ОНӨААТҮГ (Ц.Баттөр), Нийслэлийн Замын хөгжлийн газар (Г.Баярсайхан), “Улаанбаатар зам засвар, арчлалтын газар” ОНӨААТҮГ (Б.Галхүү), Чингэлтэй дүүргийн “Чингэлтэй хөрөнгө оруулалт бүтээн байгуулалтыг дэмжих төв” ОНӨТҮГ (Ц.Содхүү), Чингэлтэй дүүргийн “Хайрхан хөгжлийн төв” УТҮГ (Б.Дэлгэрбат)-т тус тус үүрэг болгосугай.

3. Энэ захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Өмчийн харилцааны газар (Ч.Сайханбаяр)-т даалгасугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА  
БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН  
ЗАХИРАГЧ

Д.СУМЬЯАБАЗАР



Нийслэлийн Засаг даргын 2023 оны  
 08 сарын 07-ны өдрийн  
 захирамжийн  
 хавсралт

БАЛАНСААС БАЛАНСАД ШИЛЖҮҮЛЭХ ТЭЭВРИЙН ХЭРЭГСЭЛ

№	Хөрөнгийн нэр	Марк	Улсын дугаар	Арлын дугаар	Үйлдвэр-лэсэн он	Тоо хэмжээ	Бүртгэлийн үнэ	Хуримтлагдсан элэгдэл	Үлдэх өртөг	Өмч эзэмшигч байгууллагын нэр	Шилжүүлэх байгууллага
1.	Суудлын автомашин	Волксваген Жетта	03-16 УНУ	WWWZZZ16Z DM066236	2013	1	43,720,000.00	38,497,888.68	5,222,111.32	Нийслэлийн "Төр захиргааны авто бааз" УТҮГ	Улаанбаатар хотын музей
2	Микро автобус	Хьюндай старекс	01-74 УАК	KMJWA37KB EU559340	2014	1	44,000,000.00	44,000,000.00	-		"Улаанбаатар хотын тогтвортой зам тээврийн төсөл"
3	Суудлын автомашин	Лексус ЛХ-570	11-86 УБУ	JTJHY7AX6B 4063094	2011	1	181,250,000.00	181,250,000.00	-	Нийслэлийн "Төр захиргааны авто бааз" УТҮГ	Нийслэлийн "Онцгой байдлын хэлтэс"
4	Микро автобус	Хьюндай старекс	30-27 УНЯ	KMJWA37KA FU694448	2015	1	55,670,000.00	30,154,583.55	25,515,416.45	Нийслэлийн "Төр захиргааны авто бааз" УТҮГ	Нийгмийн хамгааллын тусгай төв
5	Суудлын автомашин	Хьюндай элентра	03-28 УНУ	KMHDG41C BDU687471	2012	1	31,500,000.00	31,500,000.00	-		
6	Микро автобус	Хьюндай старекс	26-26	KMJWA37KB FU724442	2016	1	48,475,742.00	46,405,650.00	2,070,092.00	Нийслэлийн "Өмчийн харилцааны газар"	"Зорчигч тээврийн нэгтгэл" ОНӨААТҮГ

7	Суудлын автомашин	Форд рэнжер	20-76 УБЯ	MNCLMFF80 NW219803	2022	1	108,000,000.00	-	108,000,000.00	“Улаанбаатар зам засвар, арчлалтын газар” ОНӨААТҮГ	Нийслэлийн “Замын хөгжлийн газар”
8	Микро автобус	Хьюндай старекс	04-97 УНӨ	KMJWA37RB EU635437	2014	1	54,480,000.00	32,959,634.00	21,520,366.00	Чингэлтэй дүүргийн “Иргэдийн төлөөлөгчдийн хурал”	“Улаанбаатар зам засвар, арчлалтын газар” ОНӨААТҮГ
9	Бага оврын ачааны автомашин	Хьюндай портер	95-32 УАМ	KMFZCZ7JAB U701493	2021	1	37,673,208.00	10,988,019.00	26,685,189.00	Чингэлтэй дүүргийн “Нийтлэг үйлчилгээний газар”	Чингэлтэй дүүргийн “Хөрөнгө оруулалт бүтээн байгуулалтыг дэмжих төв”
10	Бага оврын ачааны автомашин	Хьюндай портер	95-33 УАМ	KMFZSZ7JA AU677555	2021	1	37,673,208.00	10,988,019.00	26,685,189.00		“Хайрхан хөгжлийн төв”
11	Бага оврын ачааны автомашин	Хьюндай портер	95-34 УАМ	KMFZCZ73J AAU603153	2021	1	37,673,208.00	10,988,019.00	26,685,189.00		
Нийт дүн							680,115,366.00	437,731,813.23	242,383,552.77		